



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 10 сарын 23 өдөр

Дугаар А/204

Мандалговь

“Ган ТЭТ Девелопмент” ХХК-тай
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн А/52 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд 12 хүний суудалтай автомашин” нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Ган ТЭТ Девелопмент” ХХК-тай 39,050,000 (гучин есөн сая тавин мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан техникийн үзүүлэлтийн дагуу “Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд 12 хүний суудалтай автомашин” нийлүүлэх ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Ган ТЭТ Девелопмент” ХХК-ийн захирал (С.Гантөмөр)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Үйлчилгээний албаны дарга (Ш.Оюун) ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482050812